



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2014 оны 09 сарын 25 өдөр

Дугаар А/52

Улаанбаатар хот

Зочид буудал, дэн буудал, амралтын
газрын үйл ажиллагаа эрхлэх
зөвшөөрөл олгох, сунгах тухай

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам"-ын 5.1 дэх хэсэг, Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмийн 2.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS4588:2008" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан иргэн, аж ахуйн нэгжүүдэд зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосугай.

2. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS4588:2008" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын хоёрдугаар хавсралтад дурдсан иргэн, аж ахуйн нэгжүүдийн зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай сунгасугай.

3. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Аялал жуулчлал, дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS5738:2007" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын гуравдугаар хавсралтад дурдсан иргэн, аж ахуйн нэгжүүдэд дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосугай.


4. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS5738:2007" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын дөрөвдүгээр хавсралтад дурдсан иргэн, аж ахуйн нэгжүүдийн дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай сунгасугай.

5. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Аялал жуулчлал, амралтын газарт тавигдах ерөнхий шаардлага MNS6043:2009" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын тавдугаар хавсралтад дурдсан иргэн, аж ахуйн нэгжүүдэд амралтын газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосугай.

6. Энэхүү тушаалыг нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг мэргэжилтэн /С.Туул/-д үүрэг болгосугай.


7. Зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг ахлах нягтлан бодогч /П.Ариунаа/-д даалгасугай.

ДАРГА



Э.БАТТУЛГА

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2014 оны 09 сарын 25 өдрийн
тоот тушаалын нэгдүгээр хавсралт



ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ
ОЛГОХ ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖИЙН НЭРСИЙН
ЖАГСААЛТ


2014.09.25

Улаанбаатар хот

<i>Д/д</i>	<i>Иргэн, аж ахуйн нэгжийн нэр</i>	<i>Оноосон нэр</i>	<i>Байршил</i>
1	Түм Арвижих ХХК	Дотно	Чингэлтэй дүүрэг, 3-р хороо, Урт цагаан

-ooOoo-

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2014 оны 09 сарын 25 өдрийн
тоот тушаалын хоёрдугаар хавсралт



ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ
СУНГАХ ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖИЙН НЭРСИЙН
ЖАГСААЛТ


2014.09.25

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Оноосон нэр	Байршил
1	Эрдэнэбулган ХХК	Хархорин	Чингэлтэй дүүрэг, 2-р хороо, Их тойруу 37
2	Эзэн төр ХХК	Мөрөн	Баянгол дүүрэг, 8-р хороо, Дилав хутагт Жамсранжавын гудамж 1

-ooOoo-

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2014 оны 09 сарын 25 өдрийн
тоот тушаалын гуравдугаар хавсралт



ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ
ОЛГОХ ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖИЙН НЭРСИЙН
ЖАГСААЛТ

2014.09.25


Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Оноосон нэр	Байршил
1	ГББТ ХХК	Хаус 25	Баянгол дүүрэг, 6-р хороо, 10-р хороолол АОС-24
2	Бат Бадруун ХХК	Бадруун	Сүхбаатар дүүрэг, 13-р хороо, Рашааны 8/504
3	Эс пи би ХХК	Соёмбо	Сүхбаатар дүүрэг, 16-р хороо, 34/4
4	Алтдын гол ХХК	Алтдын гол	Сүхбаатар дүүрэг, 13-р хороо, Рашааны 13/673
5	Өн Цаг Өлзий ХХК	Өн цаг	Сонгинохайрхан дүүрэг, 7-р хороо, Баянхошууны 6/54

-ooOoo-

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2014 оны 09 сарын 25 өдрийн
тоот тушаалын дөрөвдүгээр хавсралт

А/Б



ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ
СУНГАХ ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖИЙН НЭРСИЙН
ЖАГСААЛТ


2014.09.25

Улаанбаатар хот

<i>Д/д</i>	<i>Иргэн, аж ахуйн нэгжийн нэр</i>	<i>Оноосон нэр</i>	<i>Байршил</i>
1	Нью жаско ХХК	Марс	Баянгол дүүрэг, 17-р хороо, Жалханз хутагт Дамдинбазарын гудамж

-ooOoo-

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2014 оны 09 сарын 25 өдрийн
тоот тушаалын тавдугаар хавсралт



АМРАЛТЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРЛИЙГ
ОЛГОХ ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖИЙН НЭРСИЙН
ЖАГСААЛТ

2014.09.25

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, Аж ахуйн нэгжийн нэр	Оноосон нэр	Байршил
1	Бумбат тур ХХК	Бумбат резорт	Баянзүрх дүүрэг, 11-р хороо, Бумбатын ам

-ooOoo-